



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар A-32

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.6, 43.2.9; 43.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Чанаргүй активыг бууруулах стратегийн бичиг баримт”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Банкны чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журам”-ыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Үлгэрчилсэн журамд нийцүүлэн дотооддоо мөрдөх журмыг батлан мөрдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг нийт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.

3.Банкны чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журмын хэрэгжилтийг банкинд хянан шалгах удирдамжийн загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4.Үлгэрчилсэн журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Батсайхан Н.БАЯРСАЙХАН

Н.БАЯРСАЙХАН

14 02 06

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2019 оны 01 дүгээр сарын 28.-ны өдрийн
4-р дугаар тушаалын I дүгээр хавсралт



**БАНКНЫ ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ
УДИРДЛАГА, ТОГТОЛЦОО, ТАЙЛАГНАХ
ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр бүлэг. Чанаргүй активыг бууруулах стратеги

2. Чанаргүй активыг бууруулах стратеги боловсруулах
3. Чанаргүй активыг шийдэх ажиллагаа
4. Чанаргүй активыг бууруулах зорилт
5. Чанаргүй активтай ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө
6. Чанаргүй активыг бууруулах стратегийн нийцэл

Хоёрдугаар бүлэг. Чанаргүй активыг бууруулах удирдлага, засаглал

7. Гүйцэтгэх удирдлагын үүрэг, оролцоо
8. Аутсорсинг
9. Удирдлагын мэдээллийн систем
10. Чанаргүй активтай ажиллах нэгж /Тусгай активын нэгж/
11. Урьдчилан сэргийлэх ажиллагаа
12. Чанаргүй активыг шийдэх ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ

Гуравдугаар бүлэг. Чанаргүй активыг бууруулах ажлын тайлagnal

13. Тайлagnal

- 13.1. Дотоод тайлagnal
- 13.2. Хяналт шалгалтын тайлagnal
- 13.3. Олон нийтэд мэдээлэх

14. Хяналт, хариуцлага

Хавсралтууд

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь банкны удирдлагаас чанаргүй активаа бууруулах, төлүүлэх ажиллагааг төлөвлөх, удирдах, хэрэгжүүлэх, хянах болон тайлагнах тогтолцоог банк өөрийн үйл ажиллагааны цар хүрээ, опцлогт пийцүүлэн бүрдүүлэх шаардлага, чиглэлийг тогтооход оршино.
- 1.2. Банкны чанаргүй активын удирдлагын тогтолцоо нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна:
 - 1.2.1. Чанаргүй активыг үр ашигтай удирдах банкны дотоод чадавхийг тодорхойлох **дотоод-үнэлгээг** хийж гүйцэтгэдэг байх;
 - 1.2.2. Банк нь чанаргүй активыг бууруулах стратеги **боловсруулж, гүйцэтгэлийг** хууль, тогтоомжийн хүрээнд холбогдох бусад дотоод журмаар зохицуулан хэрэгжүүлж, шаардлагатай мэдээллийг удирдлагын мэдээллийн системээр дамжуулан зохих түвшинд тогтмол хүргэж байх;
 - 1.2.3. Монголбанк, банкны удирдлага болон олон нийтэд чанаргүй активыг бууруулах үйл ажиллагааны талаар тогтоосон хугацаанд тайлагнах.
- 1.3. Энэхүү журам нь Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.4. Банк нь энэхүү журамд нийцүүлэн чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журам, заавар, бусад баримт бичгийг баталж мөрдүүлнэ.
- 1.5. Дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.5.1. “Чанаргүй зээл, активаа эргэн толох зээлдэгчийн чадамжийн үнэлгээ” гэж зээлдэгч зээлээ эргэн төлж чадах эсэх боломжийг судалсан үнэлгээг;
 - 1.5.2. “Урьдчилан сэргийлэх үзүүлэлт” гэж зээл, авлагын гэрээний нөхцөл зөрчигдөх, авлагатай этгээдийн санхүү, төлбөрийн чадварт нөлөөлөх зэргээр зээл, авлага эргэн төлөгдөх боломж буурах шинж тэмдэг, дохио болсон нөхцөлийг банкнаас тогтоосон тоон болон чанарын хүчин зүйлсийг;
 - 1.5.3. “Чанаргүй актив” гэж Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу хэвийн бус, эргэлзээтэй, муу ангилалд хамаарах болон эрсдэлийн сангаас хорогдуулсан активыг;
 - 1.5.4. “Чанаргүй активыг бууруулах ажиллагаа” гэж тухайн активтай холбоотой гэрээг цуцлах, өөрчлөх зэргээр активын эрсдэлийг бууруулах, шилжүүлэх, багасгах замаар банкнаас чанаргүй активыг эргэн төлүүлэх зорилгоор энэхүү журмын 3.2-т тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахыг;
 - 1.5.5. “Чанаргүй активтай ажиллах үйл ажиллагааны төловлогоо” гэж чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг хугацаа, төсөв, хариуцах үүрэг, чиглэл, хүний нөөц зэрэг бүхий л хүчин зүйлсийг хамруулан хийгдэх ажил тус бүрийг бүлэг, хэсэг, задаргаагаар нь гаргасан гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг;

- 1.5.6. “Чанаргүй активын дотоод-үнэлгээ” гэж банк нь тогтоосон хугацааны дотор чанаргүй активаа бууруулж, эргэн төлүүлэлтийг сайжруулах чадамжаа дотооддоо үнэлэхийг;
- 1.5.7. “Чанаргүй активыг бууруулах стратеги” гэж чанаргүй активаа хамгийн ихээр бууруулахын тулд банк нь өөрийн удирдлага зохион байгуулалт, арга барил, зорилтоо тогтоосон иж бүрэн төлөвлөгөөний бичиг баримтыг;
- 1.5.8. “Чанаргүй активыг бууруулах зорилт” гэж чанаргүй активын нийт болон цэвэр дүнг бууруулах тодорхой тоон зорилтыг;
- 1.5.9. “Чанаргүй активтай ажиллах иэгж” гэж чанаргүй активыг барагдуулах чиг үүрэг бүхий үндсэн ажил үүргийн хуваарьтай банкны бүтэц, зохион байгуулалтын газар, хэлтэс, алба зэргийг хэлнэ.;
- 1.5.10. “Бүтэц өөрчлөх” гэж Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын 2.4-д заасныг;
- 1.5.11. “Хураагдсан хөрөнгө” гэж, гэрээ болон хуулийн дагуу банкны өмчлөлд шилжүүлэн авсан хөрөнгийг.

ИЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

2. Чанаргүй активыг бууруулах стратеги боловсруулах

- 2.1. Банк нь чанаргүй активыг эргэн төлүүлэх ажлын удирдлага зохион байгуулалт, аргачлал, зорилт, үйл ажиллагааг тусгасан стратегийн бичиг баримтыг боловсруулж, Гүйцэтгэх удирдлагаас баталж, хэрэгжүүлнэ. Стратеги нь дөрвөн үе шаттай байна. Үүнд:

Нэгдүгээрт: Чанаргүй активын дотоод-үнэлгээ

- 2.2. Банк нь энэхүү журмын 4.1-д тусгасан чанаргүй активыг бууруулах зорилтод хүрэхэд шаардагдах хүчин чадал, давуу болон сул тал, дутагдал, сайжруулах шаардлагатай асуудал зэрэг бүхий л нөхцөл байдлыг хамруулан дотоод-үнэлгээг жил бүр хийнэ.
- 2.3. Дотоод-үнэлгээгээр дараахь хүчин зүйлсийг шалгаж, дүгнэнэ:
 - 2.3.1. Чанаргүй активын хэмжээ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс:
 - 2.3.1.1. Чанаргүй активын багцын төрөл, хэмжээ, өөрчлөлт;
 - 2.3.1.2. Чанаргүй активын багцыг өсгөж буй гол нөлөөлөгч хүчин зүйлс, шалтгаан, бусад уялдаа, холбоос;
 - 2.3.2. Чанаргүй активыг бууруулах талаар авсан ажиллагааны үр дүн:
 - 2.3.2.1. Хэрэгжүүлсэн ажиллагаа (бүтэц өөрчлөх ажиллагааг оруулснаар)-ны төрөл, хэлбэр;
 - 2.3.2.2. Хэрэгжүүлсэн ажиллагааны үр дүн, ололттой тал, туршилага, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс (бүтэц өөрчлөх арга хэмжээг оруулснаар).

2.3.3. Стратегийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, мэдээллийн технологи, ажилтан/мэргэжилтэн, шийдвэр гаргалт, бодлого зэрэг нь дор дурьдсан үйл ажиллагаа тус бүрт хангалттай эсэх:

- 2.3.3.1. Чанаргүй активыг илрүүлэх болон үүсэхээс урьдчилан сэргийлэх;
- 2.3.3.2. Бүтэц өөрчлөх;
- 2.3.3.3. Эрсдэлийн сан байгуулах;
- 2.3.3.4. Барьцааг үнэлэх;
- 2.3.3.5. Эргэн төлүүлэх,
- 2.3.3.6. Хууль, хяналтын байгууллагад хандах эсэхийг шийдвэрлэх;
- 2.3.3.7. Өмчлөх бусад хөрөнгийн удирдлага, борлуулалт;
- 2.3.3.8. Чанаргүй активыг хянах, тайлагнах болон чанаргүй активын ажиллагааны үр дүнг хэлэлцэх.

2.4. Банк нь жил бүр дотоод үнэлгээгээ дүгнэж, шинэчилнэ.

Хоёрдугаарт: Үйл ажиллагааны гадаад орчны үнэлгээ

2.5. Банкнаас үл хамаарах гадаад орчинг дараах хүчин зүйлсийг хамруулан үнэлнэ:

- 2.5.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв (үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөдөлгөөн, тодорхой салбар (уул уурхай, хөдөө аж ахуй гм.)-т төвлөрсөн бол тухайн салбарын динамикийг шинжлэн судлах гэх мэт);
- 2.5.2. Зах зээлийн хүлээлт, төсөөлөл (үнэлгээний агентлаг, зах зээлийн шинжээч, үйлчлүүлэгчид гэх мэт);
- 2.5.3. Чанаргүй активыг худалдан авах зах зээл байгаа эсэх, байгаа бол түүний нөхцөл, шаардлага;
- 2.5.4. Хууль, эрх зүй, шүүхийн тогтолцоо болон зохицуулалт;
- 2.5.5. Татварын нөлөөлөл;
- 2.5.6. Бусад хүчин зүйлс.

Гуравдугаарт: Чанаргүй активыг бууруулах стратегийг боловсруулах

2.6. Стратегийг боловсруулахдаа дараах үндсэн хэсгүүдийг багтаана:

- 2.6.1. Чанаргүй активыг бууруулах зорилтыг цаг хугацааны мөчлөг тус бүрт харгалзах дүн болон хувиар;
- 2.6.2. Урт, дунд, богино хугацаанд чанаргүй активын стратегийн зорилтод хүрэх чанаргүй активыг шийдвэрлэх ажиллагааны хувилбарууд;

2.6.3. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.

Доровдүгээрт: Чанаргүй активын стратегийн өөрийн хөрөнгөд тусах нөлөөллийг үнэлэх

2.7. Өөрийн хөрөнгөд учруулах стратегийн нөлөөллийг банк тооцож, үнэлэх.

3. Чанаргүй активыг шийдэх ажиллагаа

3.1. Банк нь дотоод-үнэлгээндээ үндэслэн чанаргүй активыг шийдэх ажиллагааны төрлийг сонгож, холбогдох санхүүгийн үр дагаврыг тооцдог байна.

3.2. Банк чанаргүй активыг шийдэх ажиллагааны дараах төрлийг хооронд нь харьцуулан, аль тохиромжтойг нь тухайн активыг эргэн төлүүлэх боломжийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн ажиллагааны хэлбэр болгон сонгоно. Үүнд:

- 3.2.1. Хугацааг шинэчлэн тохирох;
- 3.2.2. Активыг худалдах;
- 3.2.3. Эрсдэлийн сангаар хорогдуулах;
- 3.2.4. Барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах;
- 3.2.5. Активын бүтэц өөрчлөх (Хавсралт 9);
- 3.2.6. Активын хэлбэрийг өөрчлөх;
- 3.2.7. Шүүхийн бус замаар шийдвэрлэх,
- 3.2.8. Шүүхэд хандах;
- 3.2.9. Цагдаагийн байгууллагад хандах;
- 3.2.10. Зээлдэгчид дампуурлын хэрэг үүсгэж, шийдэх;
- 3.2.11. Бусад.

3.3. Хэрэв энэхүү журмын 3.2-т дурьсан чанаргүй активыг шийдэх ажиллагаа нь дунд хугацаанд тодорхой зээлийн багцыг буюу тухайлсан активыг үр дүнтэй бууруулаагүй бол цаг алдалгүйгээр эрсдэлийн санг зохих хэмжээгээр байгуулах шаардлагатай.

3.4. Стратегид чанаргүй активыг шийдэх ажиллагааны талаар дараах зүйлсийг тусгана:

- 3.4.1. Активын төрөл, багц болон дэд төрөл, багц тус бүрт тохируулж авах ажиллагаа;
- 3.4.2. Чанаргүй активыг шийдэх ажиллагааг зохистой, хэрэгжихүйц байлгахын тулд ажиллагаа тус бүрийн шалгуур;
- 3.4.3. Бусад.

3.5. Банк нь зээлдэгч зээлээ эргэн төлөх чадвар нь төлбөрийн хуваарийг дуустал бодитой, хэрэгжихүйц байхаар үнэлэн тооцож чанаргүй активыг шийдэх ажиллагааны төрлөө сонгоно.

3.6. Банк нь чанаргүй активыг шийдэх ажиллагааг авахдаа тухайн активт хамаарах эрсдэлийн үндсэн шалтгаан, нөхцөлийг урт, богино хугацаанд нуун далдлахад ашиглахгүй, ашиглах боломжийг олгож болохгүй.

4. Чанаргүй активыг бууруулах зорилт

- 4.1. Банк нь чанаргүй активын үлдэгдэл дүнг бууруулах тодорхой тоон зорилтыг дараах хэлбэрээр стратегид тусган баталгаажуулна. Үүнд:
 - 4.1.1. **Хугацаагаар:** богино (1 жил), дунд (2-4 жил) болон урт (5 болон түүнээс дээш жилээр);
 - 4.1.2. **Төрлоор** (жишээ нь: иргэд, байгууллага, орон сууцны зээл, хэрэглээний зээл гм);
 - 4.1.3. Шаардлагатай бол бусад хэлбэрээр.

- 4.2. Банк нь стратегид тусгасан тухайн жилийн зорилтоо өөрчлөх тохиолдолд банкны Эрсдэлийн удирдлагын хороо уг өөрчлөлтийг хэлэлцэж батална. Ийнхүү баталсан өөрчлөлтийг Монголбанкинд хүргүүлнэ.

5. Чанаргүй активтай ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө

- 5.1. Банк нь Гүйцэтгэх удирдлагаас баталсан чанаргүй активыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, гүйцэтгэлдээ хяналт тавина.
- 5.2. Банк энэ журмын 2.1-т заасан стратегийг 1-5 жилийн хугацаанд хэрхэн хэрэгжүүлэх талаар үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллана. Банк нь дотооддоо иргэдийн болон байгууллагын банк, нийслэл болон орон нутаг зэргээр үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлах байдлаар зохион байгуулна.
- 5.3. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах агуулгыг зайлшгүй тусгана:
 - 5.3.1. Зорилго, зорилтоо цаг хугацааны мөчлөгөөр тодорхойлох;
 - 5.3.2. Тодорхой үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх үүрэг хариуцлага, тайлагнах зарчим зэрэг засаглалын зохицуулалтууд;
 - 5.3.3. Амжилттай үр дүнг баталгаажуулах чанарын стандартуудыг гаргаж, үр дүнл олгох урамшууллын тогтолцоог урьдчилан тогтоох;
 - 5.3.4. Хүний нөөц ба бусад нөөцийн хэрэгцээ, шаардлага;
 - 5.3.5. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэгдсэн болон хэсэгчилсэн төсөв;
 - 5.3.6. Төлөвлөгөөнд оролцож ажиллах банкны дотоод болон гадны оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар.
- 5.4. Үйл ажиллагааны төлөвлөгөөний аливаа алдаа дутагдал, хазайлтыг онцлон тэмдэглэж, цаашид засан сайжруулах өөрчлөлтийн хамт Гүйцэтгэх удирдлагад тодорхой хугацаанд тайлагнаж, шийддэг байна.

6. Чанаргүй активыг бууруулах стратегийн нийцэл

- 6.1. Чанаргүй активыг бууруулах стратеги нь бүхэлдээ болон түүний бүрэлдэхүүн хэсэг нь банкны бусад бодлого, журам, төлөвлөгөө зэрэгтэй нийцсэн байна. Стратеги нь дараахь шаардлагатай нийцсэн байна:
 - 6.2. Банкны эрсдэлийн хяналтын тогтолцоо,
 - 6.3. Стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг тайлагнах үүрэг, хариуцлагыг тодорхой тогтоож, журамлана. Уг журмыг банкны удирдлагын мэдээллийн системтэй уялдуулах,
 - 6.4. Стратегийн бүрэлдэхүүн хэсэг нь бизнес төлөвлөгөө болон төсөвт нийцэх,
 - 6.5. Стратегийг боловсруулах, удирдах болон гүйцэтгэхтэй холбоотой удирдлага, ажилтан, бусад этгээдэд стратеги нь түүнд орсон өөрчлөлтийн хамт аливаа саад, тогторгүйгээр, тодорхой, шуурхай мэдээлэгдэж байх,
 - 6.6. Банк нь чанаргүй активыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх ажиллагаанд шууд оролцож буй удирдлага, ажилтанд багийн болон хүн тус бүрийн зорилтыг тодорхой тодорхойлж өгөх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ УДИРДЛАГА, ЗАСАГЛАЛ

7. Гүйцэтгэх удирдлагын үүрэг, оролцоо

- 7.1. Банкны Гүйцэтгэх удирдлага нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:
 - 7.1.1. Чанаргүй активыг бууруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр хянаж, шинэчлэн батлах;
 - 7.1.2. Стратегийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 7.1.3. Чанаргүй активыг бууруулах ажиллагааны удирдлагын зорилго болон урамшууллын тогтолцоог тодорхойлох;
 - 7.1.4. Стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн явцыг тавьсан зорилтой харьцуулан хянахын тулд хагас жил тутамд тусгай хурал хийх;
 - 7.1.5. Том зээл, активт авах арга хэмжээг тодорхой болгон зохих зөвшөөрөл, эрхийг олгох;
 - 7.1.6. Чанаргүй активын засаглалтай холбоотой бодлого, журмыг баталж, холбогдох ажилтнуудад тодорхой мэдээлэх;
 - 7.1.7. Чанаргүй активыг бууруулах үйл ажиллагааг удирдах ажилд дотоод хяналтын тогтолцоог хангалттай болгох (чанаргүй активын ангилал, эрсдэлийн сан байгуулах, барьцааны үнэлгээ, активын бүтэц өөрчлөхтэй холбоотой шийдвэрт онцгой анхаарал хандуулах гм);

7.1.8. Чанаргүй активыг бууруулах ажлыг удирдах туршлагатай байх. Их хэмжээний чанаргүй активтай гэж үзсэн системийн ач холбогдолтой банкнаас чанаргүй активыг тухайлсан хариуцсан эрх бүхий албан тушаалтантай байхыг Монголбанк шаардаж болно.

8. Аутсорсинг

8.1. Банк үйл ажиллагааны зарим хэсгийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн (аутсорсинг) тохиолдолд банк нь энэхүү журмын шаардлагыг бүрэн хангах үүрэгтэй бөгөөд дараах нөхцөлийг мөн дагаж мөрдөнө:

- 8.1.1. Гүйцэтгэх удирдлага нь үүрэг хариуцлагаа аутсорсингоор төлөөлүүлэхгүй байх;
- 8.1.2. Аутсорсингтой холбоотой аливаа гэрээ байгуулах, удирдах болон цуцлахдаа банк зохих анхаарал хандуулдаг байх;
- 8.1.3. Аливаа аутсорсингийн зохицуулалтын дагуу үйлчилгээ үзүүлэгч нь чадвартай, найдвартай байх ёстай бөгөөд аутсорсингийн үүрэг, үйлчилгээ, үйл ажиллагааг найдвартай, мэргэжлийн гүйцэтгэх;
- 8.1.4. Аутсорсингийн үйлчилгээний гүйцэтгэлийг шаардахын тулд банк нь үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэлийг үнэлэх стандарт аргачлалыг тогтоож, гэрээндээ тусгах;
- 8.1.5. Үйлчилгээ үзүүлэгч үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг хангаж чадахгүй тохиолдолд зохих арга хэмжээг авах;
- 8.1.6. Банк нь аутсорсинг хийхтэй холбоотой эрсдэлийг удирдаж, аутсорсингийн үүргийг хянах ёстай бөгөөд эдгээр үүргийг хянах, тэдгээрийг удирдан зохицуулах мэргэшсэн чадвараа алдахгүй байх шаардлагатай;
- 8.1.7. Зайлишгүй шаардлагатай үед аутсорсингийн гэрээг цуцлах боломжтой байх;
- 8.1.8. Үйлчилгээ үзүүлэгч нь банк болон түүний харилцагчтай холбоотой аливаа нууц мэдээллийг хадгалах;
- 8.1.9. Банк нь аутсорсингийн үйлчилгээ авсан, өөрчилсөн, цуцалсан бол тухай бүр Монголбанкинд энэ тухай мэдэгдэнэ.

9. Удирдлагын мэдээллийн систем

9.1. Чанаргүй активыг бууруулах стратегийг дэмжих үр ашигтай удирдлагын мэдээллийн систем нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- 9.1.1. Банкны дотооддоо гаргадаг тайлангаас чанаргүй активын удирдлагад хамаарах мэдээллийг агуулсан тайлан;
- 9.1.2. Монголбанкинд хүргүүлдэг тайлангаас шаардлагатайг нь;

- 9.1.3. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зээлийн бүртгэл мэдээллийн сан, шинжилгээ, судалгаа хийх боломжтой байх;
- 9.1.4. Урьдчилан сэргийлэх үзүүлэлтэд үндэслэн хүндэрч болзошгүй активыг **буцаан дуудах зовшоөрлийг** урьдчилан сэргийлэх тогтолцоогоор нэвтрүүлсэн байх;
- 9.1.5. Зээл олголтын анхны судалгаа, үнэлгээ хийхэд ашигласан бүх өгөгдөл мэдээлэл болон түүнээс хойш зээлдэгчийн талаар хийсэн судалгаа, үнэлгээг системтэй бүртгэх, хялбархан сэргээх боломжтой байх.

10. Чанаргүй активтай ажиллах нэгж /тусгай активын нэгж/

- 10.1. Чанаргүй актив нь нийт активын 4%-аас дээш, анхаарал хандуулах болон чанаргүй актив нь нийт активын 8%-аас дээш түвшинд хүрсэн эсхүл чанаргүй активын тоо нь нэг зуугаас олон болсон нөхцөлийн аль нэг бүрдвэл банк нь чанаргүй активын үйл ажиллагааг хариуцдаг тусгай нэгжтэй байх бөгөөд уг нэгжийг зээл олголт, хэвийн зээлийн удирдлагаас тусад нь байгуулна. Нэгж нь газар, хэлтэс, алба гэх мэт банкны онцлогт тохирсон нэrtэй байх бөгөөд удирдлага, ажилтны тоог банк өөрсдийн үйл ажиллагаа, ажлын цар хүрээтэй уялдуулан уян хатан байдлаар тухай бүр зохицуулна.
- 10.2. Банкны дотоод аудит нь чанаргүй активтай ажиллах нэгжийн үйл ажиллагаанд болон дараалсан хяналтын тогтолцоо зохистой эсэхэд зохих хэмжээгээр хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 10.3. Банк нь чанаргүй активтай ажиллах нэгжийг дараахь боломжоор хангана:
 - 10.3.1. Холбогдох бүх мэдээлэл, бичиг баримттай танилцах эрхтэй байх;
 - 10.3.2. Чанаргүй активыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх;
 - 10.3.3. Чанаргүй активыг бууруулах ажиллагааг үр дүнтэй явуулах, хяналт тавих;
 - 10.3.4. Чанаргүй активыг шийдвэрлэсэн ажлын үр дүн, гүйцэтгэлтэй нь уялдуулж чанаргүй активтай ажиллах нэгж, ажилтан, удирдлагыг урамшуулах тогтолцоог нэвтрүүлэх.
- 10.4. Чанаргүй активтай ажиллах нэгжийн ажилтнууд зохих түвшинд мэргэшсэн байх нь зохистой бөгөөд ажилтны болон багийн гүйцэтгэлийг тогтсон хугацаанд хэмжиж, хянах харилцааг журамласан байна.

11. Урьдчилсан сэргийлэх ажиллагаа

- 11.1. Хэвийн зээлийн чанарыг хянаж, зээлийн чанар муудахаас сэргийлэхийн тулд банк нь үүргээ гүйцэтгэхгүй байж болзошгүй харилцагчдыг аль болох урьдчилан тодорхойлж, арга хэмжээ авахын тулд хангалттай дотоод зохицуулалт, мэдээлэл, тайлагнالыг хэрэгжүүлнэ.
- 11.2. Банк нь зээлдэгч болон зээлийн багцын түвшинд тохирсон урьдчилан сэргийлэх үзүүлэлтийг гадаад болон дотоод хүчин зүйлсийг харгалzan үзэж боловсруулна:
- 11.3. Банк нь урьдчилан сэргийлэх үзүүлэлтийн гол шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтай эргэн хянах тогтолцоог бүрдүүлнэ.

11.4. Урьдчилан сэргийлэх үзүүлэлт зөрчигдвэл тухайн активт үүссэн дохиог өргөтгөн судлах ажиллагааг үргэлжлүүлиэ.

12. Чанаргүй активыг шийдэх ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ

12.1. Банк нь чанаргүй активт авч буй ажиллагааны үр дүнг сайжруулахын тулд зохистой арга хэрэгсэл, ажлын дарааллыг ашиглана:

12.1.1. Чанаргүй активын бодлого, ажлын дараалал нь нийцтэй эсэхийг тогтмол хянах чанарын баталгаажуулалтын шалгалтыг нийт багцыг төлөөлөхүйц активт хийх;

12.1.2. Үр ашиг болон үр дүнг хэмжих Гүйцэтгэлийн Шалгуур Үзүүлэлтийг нэвтрүүлэх;

12.1.3. Эрсдэлийн төрлөөр нь эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд (эрсдэлийн үндсэн төрлүүд, зээлдэгчийн эрсдэл өндөр/дунд, цар хүрээ, давтамж гм)-ийг тогтоож, хянах давтамжийг тодорхойлох;

12.1.4. Зөрчигдсөн гэрээ болон төлбөр хэтрэлт /дифолт/ дахин үүсгэж буй нөхцөл шалтгаан болон засах зохистой аргын талаарх зорилтот шинжилгээ;

12.1.5. Хамтын ажиллагаа сайтай буюу зээлээ буцаан төлөх чадамжтай зээлдэгчийг дахин тодорхойлох аргачлалыг тодорхой болгох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ТАЙЛАГНАЛ

13. Тайлагнал

13.1. **Дотоод тайлагнал.** Банк дараахь байдлаар ТУЗ-ийн эсхүл ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд чанаргүй активын үйл ажиллагаа, үр дүнг тайлагнана:

13.1.1. Чанаргүй активын дотоод-үнэлгээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

13.1.2. Чанаргүй активыг бууруулах стратегийг жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор;

13.1.3. Хавсралт 1-8 дахь тайланг банкны чанаргүй активын хэмжээнээс шалтгаалж багадаа хагас жил тутамд;

13.1.4. Чанаргүй активтай ажиллах нэгжийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх тайланг улирал тутамд;

13.1.5. Бусад шаардлагатай тайлан, мэдээг банк дотооддоо журамлана.

13.2. **Хяналт шалгалтын тайлагнал:** Банк нь дараахь байдлаар Монголбанкны Хяналт шалгалтын газарт тайлагнана:

13.2.1. Жил бүрийн 10-р сарын 31-ны өдрийн байдлаарх чанаргүй активын дотоод-үнэлгээг тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

- 13.2.2. Дараагийн жилүүдэд хэрэгжүүлэх чанаргүй активыг бууруулах стратегийг Гүйцэтгэх удирдлагаас баталснаар жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор;
- 13.2.3. Энэ журмын Хавсралт 1 болон Хавсралт 4-8 дахь тайлангуудыг улирал бүрийн эцсийн байдлаар дараа сарын 15-ны өдрийн дотор бичгээр болон цахимаар;
- 13.2.4. Чанаргүй активын хяналтын тайланг шаардсан үед;
- 13.2.5. Чанаргүй активыг бууруулах стратеги болон чанаргүй активыг бууруулах зорилтыг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр;
- 13.2.6. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээ, тайланг тухай бүр.

13.3. **Олон нийтэд мэдээлэх:** Банк нь хагас жилээр болон жилийн тайландаа дараах мэдээллийг тусгаж, цахим хуудаснаа нийтэлнэ:

- 13.3.1. Чанаргүй активыг бууруулах зорилтын гүйцэтгэл (Энэ журмын Хавсралт 3).

14. Хяналт, хариуцлага

- 14.1. Банкны гүйцэтгэх удирдлага нь дотоод-үнэлгээ, стратеги, зорилтыг зохистой, бодитой, хэрэгжихүйц байдлаар гаргаж холбогдох тайлангийн хамт Монголбанкинд тайлагнах үүрэгтэй.
- 14.2. Банк энэхүү журмаар заавраар зохицуулж буй чанаргүй активыг бууруулах удирдлагын бүхий л хүрээг банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоонд суулгаж, хэрэгжилтийг хянах дотоод хяналт, дотоод аудитын үүргийг холбогдох нэгжийн ажил үүргийн хуваарыт оруулах үүрэгтэй.
- 14.3. Энэ журмыг зөрчсөн нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулах үндэслэл болно.

ооо

29-30-31	Чанартай зээлийг өстөсөн бусад эх сурвалж (+)
30	Худалдаж авсан чанартай зээл
31	Чанартай зээлтэй харицагчад нэмж үүсээн актив
32=33+36	ЗЭЭЛЭС БУСАД ЧАНАРТГҮЙ АКТИВЫН ФОРЧЛЭЛТ
33=34+35	ЗЭЭЛЭС БУСАД ЧАНАРТГҮЙ АКТИВЫН НИЙТ ШИЛЖКИЛТ (+/-)
34	Хэвийн болон АХ-с бусад чанартай активд шилжсэн (+)
35	Бусад чанартай активад хэвийн болон АХ-т шилжсэн (-)
36=37+45	ЗЭЭЛЭС БУСАД ЧАНАРТГҮЙ АКТИВЫН АЖИЛЛАГДАНЫ УРДЫН
37=Σ(38+44)	ЗЭЭЛЭС БУСАД ЧАНАРТГҮЙ АКТИВ ӨСӨЛГҮҮРҮҮРЭЛТ
38	Тэнцлэд дэх зээлээс бусад чанартай активын бураалтын эх сурвалж (-)
39	Мөнгөн хөрөнгөөр эргэн төвлөгдсөн Зээлээс бусад чанартай активыг худалдсан (өрийн үлдэгдлээр)
40	Эрсдэлтнүүн сангасаас хорлогдуулсан
41	Барыгаат мөнгөн хөрөнгөөр борлуулсан
42	Өрийг хувьсагтар сольсон сэон
43	Үнэт цахискуулж шилжүүлжин
44	Бусад тохиорулга, төлөлт
45-46-47	ЗЭЭЛЭС БУСАД ЧАНАРТГҮЙ АКТИВЫГ ӨСӨСӨН БУСАД ЭХ СУРВАЛЖ (+)
46	Худалдаж авсан зээлээс бусад чанартай актив
47	ЗЭЭЛЭС БУСАД ЧАНАРТГҮЙ АКТИВТАЙ ХАРИЦАГЧДАД НЭМЖ ҮҮСЭЭН АКТИВ
БУСАД НЭМЭЛТ МЭДЭЭЛЛЭН	
48=49+50	БУГАЦ ФЕРЧИЛСАН АКТИВ (НИЙТ)
49	Үүсээс: БФ-сон чанартай актив
50	Үүсээс: БФ-сон хэвийн болон АХ актив
51	Гадны этгээдээр төлүүлж өжиллагааг гүйцэтгэхэдээ гэрээ байгуулсан ЧА-Н дун (өрийн үлдэгдэлээр)
52	Гадны этгээдээр төлүүлж өжиллагааг гүйцэтгэхэдээ гэрээ байгуулсан ЧА-Н тоо
53=Σ(54:57)	ГАРАЭГ ЧУЧАСАН АКТИВЫН ДУН (ӨРИЙН ҮЛДЭГДЭЛЭЭР)
54	Үүсээс: Шийдвэр худалдааны нийтийн байгуулсан ЧА-Н
55	Үүсээс: Шийдвэр худалдааны нийтийн байгуулсан ЧА-Н
56	Үүсээс: Газарийн худалдааны нийтийн байгуулсан ЧА-Н
57	Үүсээс: Эрэн стратэгийн ишнийн байгуулсан ЧА-Н
58=Σ(59:62)	ГАРАЭГ ЧУЧАСАН АКТИВЫН ТОО
59	Үүсээс: Шийдвэр худалдааны нийтийн байгуулсан ЧА-Н
60	Үүсээс: Шийдвэр худалдааны нийтийн байгуулсан ЧА-Н
61	Үүсээс: Газарийн худалдааны нийтийн байгуулсан ЧА-Н
62	Үүсээс: Эрэн стратэгийн ишнийн байгуулсан ЧА-Н

Тайлбар:

ЧА: Чанартай актив
 АХ: Аянхарал хандулах
 ΘБХ: Θмчих бусад хөрөнгө
 БӨ: Бүтэц өөрчлөх

ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БҮҮРҮҮЛАХ ЗОРИЛТЫН ГҮЙЦЭЛГИЙН ҮНЭЛГЭЭ
Төлөөлөн үйлчилдэх зөвлөл тайлбарыг багцнуулсага, прогрессийн эзлэх төрлийн дээрээс салгаж тайлсанж болно)



Стратеги багцадсан еэрүүн Узнын	Фондоо уганаа (Энний хий)	Дунд хувьшигаа (2-4 жилийн периодын түүнээс дээш жинтэй)	Үргүүлчидээ (5 болон түүнээс дээш жинтэй)
20 — онын — сар —	20 — онын — сар —	20 — онын — сар —	20 — онын — сар —
I хувьшигийн II хувьшигийн	I хувьшигийн II хувьшигийн	I хувьшигийн II хувьшигийн	I хувьшигийн II хувьшигийн

ЗОРИЛТ

- 1 Нийт эзэлийн багцын дүн
чанаргүй зээлийн багцын дүн
чанаргүй зээлийн хувь
- 2 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын эрсдэлийн сан
- 4 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын эрсдэлийн сан
- 5 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын гүйцэтгэлийн хувь
- 6 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын эрсдэлийн сан

7 Нийт эзэлийн багцын дүн
чанаргүй зээлийн багцын дүн
чанаргүй зээлийн хувь

8 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын гүйцэтгэлийн хувь

9=8/7 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын эрсдэлийн сан

10=8/7 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын гүйцэтгэлийн хувь

11 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын эрсдэлийн сан

12 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын гүйцэтгэлийн хувь

13=12/5 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын эрсдэлийн сан

14 Нийт эзэлийн эрсдэлийн сан
Зээлээс бусад чанаргүй активын дүн
Зээлээс бусад чанаргүй активын гүйцэтгэлийн хувь

ГҮЙЦЭТГЭЛЭЛ ДЭЛГЭРЭНГҮЙ

- Чанаргүй эзэлийн өөрчлөлт**
Чанаргүй эзэлийн нийтийг шийжихийт (+/-)
- 15=16+19
16=7+18
17 Хэвийн болон АХ-с чанаргүй эзэлдэ шийжсэн (+)
Хэвийн болон АХ-с чанаргүй эзэлдэ шийжсэн (-)
- Чанаргүй эзэлийн ажилласданын үр дүн**
Чанаргүй эзэлийн өсслүүлүүрт
Тэнцэл док чанаргүй эзэлийн бууралтын эх сурвалж (-)
- 19=10+29
20=5(21:28)
21 Мөнгөн хөрөнгөөр эрээн төлөгдсөн
чанаргүй эзэлийг худалсан (өрийн үзүүлэгчидээр)
Эрсдэлийн сангаас хоротгуулсан
Барыгааг мөнгөн хөрөнгөөр борлуулсан
Барыгааг БХ, худалдан борлуулж хөрөнгөд авсан
Өрдийг хувьцаатгар сольсон юоп
Үнэт цасксуулж шилжүүлсэн
Бусад тохиуулга, төлөгт
- 22
23
24
25
26
27
28

29=30+31	Чанаргүй эзэлэж югсөн бусад эх сурвалж (+)
30	Худалдах засан чанаргүй эзэл
31	Чанаргүй эзэлэж харилцагдал нэмж хүсгээн актив
32=33+36	
33=34+35	Зээлээс бусад чанаргүй активын шийжилтийн төслийн тодорхойлалт
34	Эзэлээс бусад чанаргүй активын ийтгэлийн (+/-)
35	Хэзийн болон АХ-с бусад чанаргүй активын шийжээн (+/-)
35	Бусад чанаргүй активын хувийн болон АХ-т шийжээн (-)
35=36	Зээлээс бусад чанаргүй активын дэвшилдэгчийн үр дүн
36=37+45	Зээлээс бусад чанаргүй активын ёсогт буруулалт
37=Σ(38+44)	Тэнцэл дэх зээлээс бусад чанаргүй активын буруулалт эх сурвалж (-)
38	Мөнгөн хөрөнгөөр эргэн төлөгсэн
39	Зээлээс бусад чанаргүй активыг худалдаан (өрийн үзүүлэлтээр)
40	Эрэлдлийн сангас хорлогдуулсан
41	Барыгааг мөнгөн хөрөнгөөр борлуулсан
42	Өграйт хувьзаагаар солбсон сэргийн
43	Үнэт цаснаасуулж шилжүүлжин
44	Бусад тохиоруулга, төлөгт
45=46+47	Зээлээс бусад чанаргүй активыг ёсогсөн бусад эх сурвалж (+)
46	Худалдах засан эзэлэс бусад чанаргүй актив
47	— Зээлээс бусад чанаргүй активтай харилцагдал нэмж хүсгээн актив
48=49+50	Бугатын ювчийн активын төслийн тодорхойлалт
49	Ичинэс: Бүрдэхийн тодорхойлалтын АХ актив
50	Ичинэс: Бүрдэхийн тодорхойлалтын АХ актив
51	
52	Гадны этгээлээр төлүүлэх эжилтлагаг гүйцэтгэх дэхжүүлэлийн төслийн тодорхойлалт
54	Гадны этгээлээр төлүүлэх эжилтлагаг гүйцэтгэх дэхжүүлэлийн төслийн тодорхойлалт
55	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
56	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
57	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
58=Σ(59+62)	Гэрээг шийнэсэн активын тоо
59	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
60	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
61	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
62	Ичинэс: Энэ сурвалжийг шийнэж болгоход
Тайлбар:	ЧА: Чанаргүй актив АХ: Ахлагчийн хандуулах ӨБХ: Өмчийн бусад хөрөнгө БҮ: Бугатын ювчийн актив

48=49+50	Бугатын ювчийн активын төслийн тодорхойлалт
49	Ичинэс: Бүрдэхийн тодорхойлалтын АХ актив
50	Ичинэс: Бүрдэхийн тодорхойлалтын АХ актив
51	
52	Гадны этгээлээр төлүүлэх эжилтлагаг гүйцэтгэх дэхжүүлэлийн төслийн тодорхойлалт
54	Гадны этгээлээр төлүүлэх эжилтлагаг гүйцэтгэх дэхжүүлэлийн төслийн тодорхойлалт
55	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
56	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
57	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
58=Σ(59+62)	Гэрээг шийнэсэн активын тоо
59	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
60	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
61	Ичинэс: Шийдвэрээс төрөлжүүлжин
62	Ичинэс: Энэ сурвалжийг шийнэж болгоход

ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ (Гүйцэтгэлийн үнэлгээ)
ОЛОН НИЙТЭД ЭНОХУУ ТАЙЛАНГ ХАГАС ЖИЛ тутамд ворийн цахим худсаар дамжуулж тайлагнаа

Хавсралт 3

ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ (Гүйцэтгэлийн үнэлгээ)		ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛТ	
ОЛОН НИЙТЭД ЭНОХУУ ТАЙЛАНГ ХАГАС ЖИЛ тутамд ворийн цахим худсаар дамжуулж тайлагнаа		ТАЙЛАНГ ЧЕНИН	
Стратеги багасгалсан 10000	Богино хувьнээс (Энэний хий)	Дунд хувьнээс (2-3 эхий)	Ургуулганы (5 болон түүнээсээнээс хий)
Чанартгүй активыг бууруулж зорилтуулж узүүлж	10_ оны _ сар _	20_ оны _ сар _	20_ оны _ сар _
Нийт зээлийн багтын дүн			
Чанартгүй зээлийн багтын дүн			
Чанартгүй зээлийн хувь			
Нийт зээлийн эрөлтийн сан			
Зээлээс бусад чанартгүй активын дүн			
Зээлээс бусад чанартгүй активын сан			
БУСАД МЭДЛЭЧЛӨСӨН АКТИВ		БУСАД МЭДЛЭЧЛӨСӨН АКТИВ	

ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ (Гүйцэтгэлийн үнэлгээ)	
Стратеги багасгалсан 10000	Богино хувьнээс (Энэний хий)
Чанартгүй активыг бууруулж зорилтуулж узүүлж	Дунд хувьнээс (2-3 эхий)
Нийт зээлийн багтын дүн	Ургуулганы (5 болон түүнээсээнээс хий)

	Хэвийн бус	Эрэлзээтэй	Муу	Нийт	Эзлэх %	Зээлийн тоо	Эзлэх %	Богино хугацаа (Эхний жили)	Дунд хугацаа (2-4 жили)	Үрг хугацаа (болов түнэс дээш жили)	ЗОРИЛТ	БИЕЛДЛТ	Бисгийг %
Байгууллагын зээл /төгрөөр/													
Уул уурхай, олборлох													
Боловсрулах гүйцвэрэл													
Бөгийн болон жижиг худалдаа													
Барилга													
Үл хөдлөх хөрөнгө													
Бусад													
Иргдийн зээл /төгрөөр/													
Ипотек													
Өрхийн үйлдвэрлэл, аж ахуйн Хэрэгжээний													
Цалингийн													
Тэгтэврэйн													
Малтны													
Картын													
Бусад													
Нийт													
Бүгд дүн													

ЧАНАРГҮЙ АКТИВЫН БУРУУЛАХ ЗОРИЛТ <i>(чадлыг дүнгэр)</i>	
Тайланын одрийн байдаларх билэгтэй	
Ботино хугацаа (Эхний жили)	Дунд хугацаа (2-4 жили)
20_ онц гард	20_ онц гард
20_ онц гард	20_ онц гард
Нийт	
Иргдийн зээл /төгрөөр/	
Ипотек	
Өрхийн үйлдвэрлэл, аж ахуйн Хэрэгжээний	
Цалингийн	
Тэгтэврэйн	
Малтны	
Картын	
Бусад	
Нийт	
Бүгд дүн	

ТАЙЛАНЫН ОДРИЙН БАЙДЛААРХ БИЛЕГТЭЙ <i>(одоржилсан тайланын үзүүлэлт дүн)</i>	
Тайланын одрийн байдаларх билэгтэй	
ЗОРИЛТ	БИЕЛДЛТ
20_ онц гард	20_ онц гард
20_ онц гард	20_ онц гард
Нийт	
Иргдийн зээл /төгрөөр/	
Ипотек	
Өрхийн үйлдвэрлэл, аж ахуйн Хэрэгжээний	
Цалингийн	
Тэгтэврэйн	
Малтны	
Картын	
Бусад	
Нийт	
Бүгд дүн	

БААНЫАР

Хавсралт 5

САЛМОЛГААНЫН МАРГ

№	Зээлжүүний нэр	Сайнбар	Активын төрөл	Олгосон отноо	Олгосон дүн	ЧАД антилсан отноо	Хугацаан хөтөрсөн хоногийн тоо	Одоогийн зинчен антлагал	Валют	Хүчээрэж өөрчөлийн ургийн үзүүлэлт	Газалд валзатын үзүүлэлт	Барылаа хөрөнгө	Барылааны үзүүлэлт	
1														
2														
3														
4														
5														
6														
7														
8														
9														
10														
11														
12														
13														
14														
15														
16														
17														
18														
19														
20														
21														
22														
23														
24														
25														
26														
27														
28														
29														
30														

НИЙТ

0 0 0 0

ТӨМ ЧАНАРГҮЙ АКТИВЫН ТАЙЛАН (банкны холбогдох этгээд)

Монголбанкнын тайлбарын

Тайлан хүрээж овхицэвэр
Хавсралт 6

№	Зээлжчийн нэр	Салбар	Активын төрөл	Огтоосон отноо	Огтоосон дун	Хувьсаа хэлжээж хөнгийн тоо	Одгоийн антлаг	Валют	Хүзүүж болжигүй үргүйн үзүүрэл	Гилдэг валютын ущаатдол	Баланс тээврийн сан	Барилга хөрөнгө	Барилга хөрөнгө түншгээ	Сая тоогуяа		
1																
2																
3																
4																
5																
6																
7																
8																
9																
10																
11																
12																
13																
14																
15																
16																
17																
18																
19																
20																
21																
22																
23																
24																
25																
26																
27																
28																
29																
30																
31																
32																
33																
34																
35																
36																
37																
38																
39																
40																
НИЙТ												0	0	0	0	

dozenes.

dozenes.

Сэдэг мэдүүлэгчид							
Хувьцаат 1				Хувьцаат 2			
Активын журнал холбогдол залт		Бүтэн юрчилсан активын		Бүтэн юрчилсан активын		Бүтэн юрчилсан активын	
Нийтийн терлиүүлэлт	Нийтийн терлиүүлэлт	Үүрээс: Акхарал жинчилж авсантай					
Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Баланс хувьцаатын бүтцийн юрчилгэлт							
Эргэн төхөөх хувьцарт юрчилж оруулж	2.4.1.1.						
Хүчиний түшиний юрчилж	2.4.1.2.						
Хүрмийлжсан хүчиний авалтыг буруулж, чөлөөлж	2.4.1.3.						
Хүгүүчдээс төлбөрт шингээж, хувьцарь юрчилж	2.4.1.4.						
Утгын хувьцаатын бүтцийн юрчилгэлт							
Хутаадаа, хувьцарьийн хонхицуулжаслаа хүгүүрүүслэн	2.4.1.5.						
Хутаадаа, хувьцарьийн сүнгэсээс үргэр цүнгэсан	2.4.1.6.						
Барьжийтай холбоотой бүтэн юрчилж	2.4.1.7.						
Хутаадаа сүнгэж	2.4.1.8.						
Гэрээнэ тусгасан нийцэнийг хөгжэх	2.4.1.10.						
Нийт							
Байгууллагын эзэлхүстэв							
Баланс хувьцаатын бүтцийн юрчилгэлт							
Эргэн төхөөх хувьцарт юрчилж оруулж	2.4.1.1.						
Хүчиний түшиний юрчилж	2.4.1.2.						
Хүрмийлжсан хүчиний авалтыг буруулж, чөлөөлж	2.4.1.3.						
Хүгүүчдээс төлбөрт шингээж, хувьцарь юрчилж	2.4.1.4.						
Утгын хувьцаатын бүтцийн юрчилгэлт							
Хутаадаа, хувьцарьийн хонхицуулжаслаа хүгүүрүүслэн	2.4.1.5.						
Хутаадаа, хувьцарьийн сүнгэсээс үргэр цүнгэсан	2.4.1.6.						
Барьжийтай холбоогийн бүтэй юрчилж	2.4.1.7.						
Орийн хувьцанд зөрвүүлж	2.4.1.8.						
Хутаадаа сүнгэж	2.4.1.9.						
Гэрээнэ тусгасан нийцэнийг хөгжэх	2.4.1.10.						
Нийт							

Эзэлжүүн нэр	Өмчлөлдөө авсан хөрөнгө төрөл(сонгог)	Банкны бүртгэлээд ажсан отбоо	Үндэс	Стандартын чадалгүйний отбоо	Стандартын чадалгүйний дугаар	Байгуулсан эрсдэлийн сан	Худалдан борлуулах ЗӨРҮЛЛӨТ	
							Богино хугацаа (Эхний дүүр хугацаа (2-4 жилийн түүвэс дараа жил)	20 онд сар
Мянган хөөнөгийн хадгаламж гк)								
Биетдэг, эмнэгэ								
Үнэт цас - МХБ-д бүртгэгдэй ХК								
Үнэт цас - МХБ-д бүртгэгдэй бонд								
Үнэт цас - МХБ-ийн								
Үнэт цас - ЗГ, Герийн оюутнай ААН								
Үнэт цас - бусад								
Ашигт магтмалын тусгай зөвшөөрөл (Хайгуул)								
Ашигт магтмалын тусгай зөвшөөрөл (Аингилт)								
Орон сууц								
Барилга - Уйчиншилээ								
Барилга - үйлдвэрээрэл								
Барилга - оффис								
Барилга - дусгалгүй								
Мал, аялган								
Газэр - эмчилж, хувийн								
Газэр - эзэмшиж хувийн								
Газэр - эзж, ахуйн зориулалттай								
Улз урхайн тоног төхөөрөмж								
Улаа урхайн хөвөнгөөнтөй мөхөнжим								
Судлын автомашин								
Бусад төрлийн автомашин								
Үйлчилэгийн тоног төхөөрөмж								
Бараа моторийн								
Хөдөлж хөрөнгө								
Бусад биеийн бус хөрөнгө								
Бусад								

Активын бүтэц өөрчлөх шийдлийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Бүтэц өөрчлөх ажиллагааг аваахдаа банк дараах зүйлсийг хийх үнэлсэн байна:

- § Урт болон богино хугацааны арга хэмжээнүүдийг хооронд нь ялгах;
- § Зээлдэгчийн нөхцөл байдал сайжирсан үед банкинд илүү таатай нөхцөл бүрдэх боломжтойгоор бүтэц өөрчлөхөөр нөхцөл тохирвол, тохиролцсон бүтэц өөрчлөлтийн нөхцөлөө шалгах эрхийг гэрээний нөхцлөөр баталгаажуулах;
- § Хэрэгжих боломжтой болон хэрэгжих боломжгүй арга хэмжээнүүдийн хоорондох ялгааг ялгаж салгах;
- § Бүтэц өөрчлөлтийн арга хэмжээ аваахаас өмнө зээлдэгчийн санхүүгийн байдлыг (зээлдэгчийн чадамжийн үнэлгээ) дараахь байдлаар бүрэн үнэлэх.
- § Зээлдэгчийн чадамжийн үнэлгээг тооцох аргачлалыг банк батлана.

Чанаргүй зээлээ эргэх төлөх зээлдэгчийн чадамжийн үнэлгээ нь зээлээ бүрэн эргэн төлөх зээлдэгчийн одоогийн болон ирээдүйн бодит чадварыг үнэлэх бөгөөд дараахь болон түүнтэй адилтгах бусад шинжилгээг үндэслэнэ. Үүнд:

- § Тогтмол орлого;
- § Зарлага;
- § Бусад хөрөнгө;
- § Бусад өр төлбөр;
- § Зайлшгүй (амжиргааны буюу үйл ажиллагааны) зардал;
- § Ажил эрхлэлтийн төлөв, хандлага;
- § Мөнгөн урсгал ба бизнес төлөвлөгөө;
- § Эргэн төлөх, хамтран ажиллах хүсэлтэй байх;
- § Бусад.

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
13.2 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Чанаргүй активыг бууруулах
удирдлага, тогтолцоо, тайлагналын журмын
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

1. Нийтлэг үндэслэл

1. Энэ удирдамжийн зорилго нь *чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагналын жсурам* (цаашид “жсурам” гэх)-д заасан банкны чанаргүй активыг удирдах зохих шаардлага, шалгуурыг Монголбанкнаас хянаж, дүгнэх харилцааг зохицуулахад оршино. Удирдамжийг чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журамтай уялдуулан хэрэглэх бөгөөд хамрах хүрээ, агуулга нь чанаргүй активын удирдлагын журамтай уялдан өөрчлөгднө.
2. Энэхүү удирдамж нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн аливаа шаардлагыг орлох буюу нөхөхгүй бөгөөд чанаргүй активын удирдлагатай холбоотой Монголбанкны хяналт шалгалтын хүсэл сонирхлыг тодруулах зорилготой хяналт шалгалтын хэрэгсэл юм.
3. Журмын 1.5 дугаар зүйлд тодорхойлсон нэр томъёоны тайлбар нь энэхүү удирдамжид адил утгаар хэрэглэгдэнэ.

2. Чанаргүй активын стратеги

1. Журмын 2-р бүлэг нь банкийг дөрвөн үе шаттайгаар чанаргүй активын стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхийг шаарддаг. 1-р үе болон 2-р үе шатны удирдамжийг доор харуулав.

1-р үе шат: Чанаргүй активын дотоод-үнэлгээ

2. Стратегийг хэрэгжихүйц, ач холбогдолтой боловсруулахын тулд банк нь стратегийг дэмжих үйл ажиллагааныхаа дотоод боломж, бололцоо, нөөц, төсөл, хязгаарлалтыг харгалзана Журмын 2.3, 2.4-р зүйлийн дагуу банк чанаргүй активыг удирдах, чанаргүй активыг бууруулах банкны чадварт нөлөөлж буй гол дотоод асуудлыг оорсдөө дотооддоо үнэлнэ.
3. Монголбанк нь банкийг чанаргүй активын дотоод-үнэлгээгээ бодитой, иж бүрэн хийж банкинд тулгарч буй хүндрэлийг тодорхойлж, дотооддоо авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхийг шаардана.
4. Банк нь журмын 13.2 дугаар зүйлийн дагуу Монголбанкинд дотоод-үнэлгээгээ тайлагнах ёстой. Шаардлагатай гэж үзвэл Монголбанк нь банкны чанаргүй активын дотоод-үнэлгээний дүгнэлтийг баталгаажуулах зорилгоор холбогдох баримтыг банкнаас хяналт шалгалтын бүрэн эрхийн хүрээнд шаардаж болно.

2-р уе шат: Үйл ажиллагааны гадаад орчны үнэлгээ

- 2.5. Банк нь чанаргүй активыг бууруулах стратеги болон чанаргүй активыг бууруулах зорилтод гадаад орчны нөхцөл байдал ямар нөлөө үзүүлж болохыг судалж мэдэн, үнэлнэ. Иймээс журмын 2.5-р зүйл нь чанаргүй активыг бууруулах стратегийг боловсруулахдаа банкнаас хамаarahгүй гадна орчны хүчин зүйлсийг харуулна. Эдгээр хүчин зүйлсийн заримыг дурдвал:
- 2.5.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал: Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөдөлгөөн болон бусад холбогдох салбарын хөдөлгөөн (жишээ нь: уул уурхай, хөдөө аж ахуй) нь чанаргүй активыг бууруулах зорилтод хүрэх чанаргүй активыг бууруулах стратегийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэдэг. Макро эдийн засгийн таатай бус нөхцөлд ч банк нь чанаргүй активаас үүсэх эрсдэлийг бууруулах зорилготой байх ёстой.
- 2.5.2. Зах зээл/хөрөнгө оруулагчдын хүлээлт: Гадны оролцоот талууд (үнэлгээний агентлагууд, зах зээлийн шинжээчид, судалгаа шинжилгээ, үйлчлүүлэгчид гэх мэт)-ын хүлээлтийг харгалзан банк нь чанаргүй активын багцаа хэр хурдан, ямар хэмжээгээр бууруулахаа тооцоолох ёстой. Олон улсын жишиг үзүүлэлтүүд, бүлгийн дүн шинжилгээг ашиглаж болно;
- 2.5.3. Чанаргүй активын хөрөнгө оруулагчийн эрэлт: Чанаргүй активын дотоодын болон олон улсын зах зээлийн чиг хандлага, өөрчлөлтийг мэдэж байх нь банкууд чанаргүй активын багцаа борлуулах магадлал, боломжит үнийг тооцоолон стратегийн ач холбогдолтой шийдвэр гаргахад тусална;
- 2.5.4. Зохицуулалт, хууль эрх зүй, шүүхийн тогтолцоо: Чанаргүй активын төрөл тус бүрт авах ажиллагааны хууль зүйн ялгаатай байдлын талаар хангалттай ойлголттой байх шаардлагатай. Ялангуяа, эдгээр ажиллагааны дундаж хугацаа, санхүүгийн үр дагавар, активын төрөл бүрт холбогдох үр дагавар (жисийн нь: барьцаатай болон барьцаагүй активын талаарх), барьцааны төрөл бүрт үзүүлэх нөлөө, харилцагчийн эрх ашгийг хамгаалах асуудлын нөлөө (иргэдийн орон сууцны зээл гм-д) болон эрх зүйн ажиллагаатай холбоотой бүхий л зардлын дундаж зэргийг үнэлж тооцоолох;
- 2.5.5. Татварын нөлөө: Чанаргүй активын эрсдэлийн сан болон сангаас хорогдуулахтай холбоотой татварын нөлөөлөл нь чанаргүй активыг бууруулах стратегид нөлөөлөхийг банкууд бүрэн ойлгож, чанаргүй активын стратегийг боловсруулахдаа анхаарч үзсэн байна.
- 2.6. Шаардлагатай гэж үзвэл Монголбанк чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журмын 2.5 дугаар зүйлд заасан гадаад хүчин зүйлсийн үнэлгээг хийхэд ашигласан нотолгоог хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх замаар банкнаас шаардаж болно.
- 2.7. Журмын 13.2-д банк нь чанаргүй активыг бууруулах стратегиа жил тутамд гаргаж Монголбанкаар хянуулахаар хүргүүлэх үүрэгтэй. Монголбанк нь банкны чанаргүй активыг бууруулах стратегийг хянан үзэж, банкны чанаргүй активыг бууруулах стратеги болон чанаргүй активыг бууруулах зорилт хангалттай бус бол өөрчлөхийг шаардаж болно. Монголбанк нь чанаргүй активыг бууруулах стратегийг

Монголбанкаас хянасны дагуу хэрэгжүүлэхийг (чанаргүй активыг бууруулах зорилтыг хамруулна) шаардана. Монголбанк нь банк, банкны ТҮЗ-ийн гишүүд нь чанаргүй активт хамаарах асуудлаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хяналт шалгалтын бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлага тавьж, зохих арга хэмжээ авна.

3. Чанаргүй активыг бууруулах удирдлага ба үйл ажиллагаа

- 3.1. Засаглалын зөв бүтэц, үйл ажиллагааны зохистой тогтолцоо бүрэлдээгүй банкууд өөрсдийнхөө чанаргүй активын асуудлыг үр ашигтай, зохистой байдлаар шийдвэрлэх боломжгүй тул журам нь чанаргүй активтай ажиллах тогтолцоо болон үйл ажиллагааны үндсэн бүтэц бүрэлдэхүүнийг тогтооход чиглэнэ.
- 3.2. Журмын 7.1 дүгээр зүйлд Гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага, шаардлагатай шийдвэр гаргалтыг тодорхойлсон. Гүйцэтгэх удирдлага нь чанаргүй активыг бууруулах удирдлагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хангалттай байлгах, чанаргүй активыг удирдахдаа мэргэшсэн байх шаардлагатай. Монголбанк нь чанаргүй активын бууруулах, чанаргүй активын эрсдэлийн түвшинд зохицохуйц хүчин чармайлт гаргахыг Гүйцэтгэх удирдлагаас шаардах нь зохистой. Монголбанк нь журамд заасан тухайлсан шаардлагыг биелүүлээгүй Гүйцэтгэх удирдлагад хяналт шалгалтын бүрэн эрхийнхээ хүрээнд зохих шаардлага тавьж, арга хэмжээ авна. Жишээлбэл, Чанаргүй актив хариуцсан эрх бүхий албан тушаалтыг чанаргүй активтай ажиллах талаарх холбогдох сургалтад хамрагдахыг шаардах гм.
- 3.3. Журмын 10-р зүйлд их хэмжээний чанаргүй активтай банкнаас чанаргүй активтай ажиллах нэгжийг зээл олголт хариуцдаг болон хэвийн зээл хариуцдаг нэгжүүдээс тусад нь байгуулж ажиллуулахыг шаарддаг. Энэ үүргийг салгах нь ашиг сонирхлын зөрчлийг удирдах, чанаргүй активтай ажиллах тусгайлсан мэдлэг, чадавхыг дээшлүүлэхэд тусална. Зээл олгох үйл явцад оролцож буй хүмүүсийг чанаргүй активтай давхар ажиллахаас зайлсхийх боломжгүй тохиолдолд банк аливаа ашиг сонирхлын зөрчлийг хангалттай хэмжээгээр бууруулах арга хэмжээг авна.
- 3.4. Чанаргүй активтай ажиллах нэгж нь чанаргүй активтай ажиллах ажиллагааны хэлбэр нь зээлдэгчийн үйл ажиллагаатай тохирсон эсэхийг баталгаажуулахын тулд чанаргүй активын өөрчлөлтийн мөчлөгийг иж бүрнээр нь анхаарч үзэх хэрэгтэй. Чанаргүй активын өөрчлөлтийн мөчлөгийн холбогдох үе шатыг дараах байдлаар хуваана:
 - 3.4.1. Хугацаа хэтрэлтийн эхэн үе (90 хоног хүртэл хугацаа хэтэрсэн): Энэ үе шатанд зээлдэгчтэй байгуулсан анхны нөхцөл, зээлдэгчийн нөхцөл байдлын нарийвчилсан үнэлгээнд шаардагдах мэдээллийг цуглуулахад гол анхаарлаа хандуулна (жисийээ нь: санхүүгийн байдал, зээлийн баримтын статус, барьцааны байдал, хамтын ажиллагааны түвшин буюу зээлдэгч нь банктай холбоотой бөгөөд зээлээ төлөх хүсэл, чармайлттай гэх мэт). Мэдээллийг цуглуулах нь зээлдэгчийн сегментчилэлийг оновчтой тогтоож, зээлдэгчтэй ажиллах хамгийн зохистой стратегийг тодорхойлдог. Энэ үе шатанд зохих ажиллагааны стратеги боловсруулахаас өмнө зээлдэгчийн санхүүгийн байдлыг тогтвортжуулахад чиглэсэн богино хугацааны бүтэц өөрчлөлтийг хэрэгжүүлж болно. Үүнээс гадна банк өөрийн байр сууриа сайжруулах хувилбарыг эрэлхийлнэ. (жисийээ нь: зээлийн талаар шинээр баримт бичигт гарын үсэг зуржс баталгаажуулах, барьцааг улам сайжруулах, монгөн гүйлгээний алдагдлыг багасгах, боломжтой бол нэмэлт барьцаа авах);

3.4.2. Хугацаа хэтрэлтийн сүүл үе/ зохион байгуулалтын өөрчлөлт/ бүтэц өөрчлөх арга хэмжээ: Энэ үе шат нь зээлийн бүтэц өөрчлөх аргыг хэрэглэх, албан ёсны болгоход чиглэнэ. Зөвхөн бүтэц өөрчлөх хувилбарууд байгаа гэж зээлдэгчийн боломжийн үнэлгээгээр тогтоосон тохиолдолд л бүтэц өөрчлөх зохицуулалтыг хийх ёстой. Бүтэц өөрчлөлтийн арга хэмжээг авсны дараа чанаргүй активын дохио цаашид ажиглагдахгүй болж, чанаргүй активтай ажиллах нэгжээс шилжүүлэх хүргэл зээлдэгчийн эрсдэл нэмэгдэх эсэхийг хянаж байх хамгийн бага хугацаа (хамгийн багадаа 1 жил)-г тодорхойлж, хяналгад байлгах нь зүйтэй;

3.4.3. Татан буулгах /зээлийг эргэн төлүүлэх/ хууль, эрх зүйн ажиллагаа / барьцааг өрөнд авах: Энэ үе шат нь зээлдэгчийн санхүүгийн байдал, хамтын ажиллагааны түвшингээс шалтгаалан бүтэц өөрчлөх шийдлийг олж чадахгүй зээлдэгчдэд чиглэгддэг. Ийм тохиолдолд банкууд эхлээд шүүхийн болон шүүхийн бус аргууд зэрэг татан буулгах хувилбаруудын зардал, үр ашгийн дүн шинжилгээг эхэлж хийнэ. Энэ шинжилгээнд үндэслэн банкууд нэгэнт сонгосон татан буулгах хувилбарыг түргэн шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай. Татан буулгах эрх зүйн болон бизнесийн мэргэшсэн туршилага нь чанаргүй активын мөчлөгийн энэхүү үе шатанд зайлшигүй чухал байдаг. Гадны мэргэжилтнүүдийг өргөнөөр ашиглаж буй банкууд нь татан буулгах ажиллагааны үр дүнтэй байдлыг хангахын тулд хангалттай дотоод хяналтын механизм бий болгоно. Олон жил болсон чанаргүй активыг тусгайлан анхаарна..

3.4.4. ӨБХ (хураан авсан буюу чанаргүй активаас үүдэлтэй бусад хөрөнгө)-ийн удирдлага; Банкууд чанаргүй активын өөрчлөлтийн мөчлөгийн өөр өөр үе шат болон багц бүрт зориулсан чанаргүй активтай ажиллах мэргэжилтнүүд болон багууд байгуулна. Бизнесийн ердийн харилцааны менежерээс чанаргүй активтай ажиллах нэгжид активыг шилжүүлэх, чанаргүй активтай ажиллах нэг нэгжээс нөгөөд шилжүүлэх “тар дамжуулах” дохио-санамжийн үзүүлэлтийг албан ёсоор тодорхойлсон удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхойлно. Дохио санамжийн үзүүлэлт нь маш ойлгомжтой тодорхойлогдсон байх бөгөөд зөвхөн нөхцөл байдлыг хөдөлбөргүй тогтоосон удирдлагын сонголтыг зөвшөөрнө.

4. Активын бүтэц өөрчлох

- 4.1. Журмын Хавсралт 9-д бүтэц өөрчлөлтийн арга хэмжээний бэлэн хувилбарууд (*Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах жсурмын 2.4-д заасан*)-аас боломжтойг нь чанаргүй активын стратегидаа тусгах боломжийг банкинд олгосон.**
- 4.2. Бүтэц өөрчлөх арга хэмжээг авах гол зорилго нь хэвийн зээлдэгч нь чанаргүй төлөвт хүрэхээс сэргийлэх, чанаргүй зээлдэгч нь чанаргүй ангилалд байгаа нөхцөлөөс гарах явдал юм. Гэсэн хэдий ч банкууд нь зээлдэгчдэд бүтэц өөрчлөх боломж олгохдоо санхүүгийн бэрхшээлийг хойшилуулах байдлаар активын чанарыг шийдвэрлэснээр тэнцэлд активын чанарыг буруу тусгахад хүргэдэг. Өөрөөр хэлбэл бүтэц өөрчлөх арга хэмжээгээр төлолтийг дахин дахин хойшилуулах нь зээлдэгчийн эргэн толох чадварын хүрээнд тулгарч буй үндсэн асуудлуудыг шийдэхгүй.**